



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн нийт 36,681,746.50 (гучин зургаан сая зургаан зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин зургаан төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

132001522

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын /...-ны өдрийн
22/0... дугаар тогтоопын хаваралт

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй
дуудлага худалдаагаар худалдаах тээврийн хэрэгслийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Нийт явсан гүйлт, км	Балансын үнэ, хуrimтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	УА3390992 пургон, 2819- ДОР, Арап№ С0473541	3/20/2012	150840	20,000,000.00	1,000,000.00
2	УА3469, 6713-ДОР, Арап№ 0001024053730	1/17/2011	155285	16,681,746.50	1,000,000.00
				36,681,746.50 Нийт дүн /гучин зургаан сая зураган зуун наян нэгэн мянга долоон зүн дөчин зураган төгрөг тавин мөнгө/	2,000,000.00 /хоёр сая/